



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Геодези, зураг зүйн тухай хуулийн 6 дугаар зүйлд дор дурдсан хэсэг нэмсүгэй:

“6.2.Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч аж ахуйн нэгж, иргэн нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ:

6.2.1.үйл ажиллагаандаа ашиглах хэмжилт, боловсруулалтын багаж хэрэгслийн жагсаалт, хувийн дугаар, гэрчилгээ;

6.2.2.мэргэжлийн боловсон хүчин болон тэдний дадлага туршлагын талаарх тодорхойлолт;

6.2.3.заавар, стандарт болон техникийн баримт бичгийн жагсаалт.”

2 дугаар зүйл. Геодези, зураг зүйн тухай хуулийн 5.4.4, 6.1.1 дэх заалтын “зөвшөөрөл” гэсний өмнө “тусгай” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Геодези, зураг зүйн тухай хуулийн 12.1.1 дэх заалт, 14.2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 12.1.1 дэх заалт:

“12.1.1.нууцын зэрэглэлтэй байр зүйн зураг, тоон мэдээллийг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай зөвшөөрөлгүйгээр хэвлэх;”

2/ 14.2 дахь хэсэг:

“14.2.Энэ хуулийн 12.1.1-д заасныг зөрчсөн этгээдэд Эрүүгийн хууль болон Төрийн нууцын тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”

4 дүгээр зүйл. Геодези, зураг зүйн тухай хуулийн 5.4.4, 6.1.1 дэх заалтын “, ажил гүйцэтгэх” гэснийг хассугай.

5 дугаар зүйл. Геодези, зураг зүйн тухай хуулийн 5.2.2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ